



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 4/13

Улаанбаатар хот

Ерөнхий боловсролын сургуулийн англи
хэлний багш нарыг чадвахжуулах сургалтад
оролцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Боловсролын ерөнхий тухай хуулийн 31.1.3, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Их хурлын гишүүн С.Амарсайханы санаачлагаар хэрэгжүүлж буй "EF Efekta" онлайн англи хэлний төслийн сургагч багш бэлтгэх сургалтад дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн англи хэл, мэдээлэл технологийн багш нарыг хамруулж чадвахжуулахыг дүүргийн Боловсролын хэлтэс (Ш.Баасансүрэн)-т үүрэг болгосугай.

2. Сургалтад шаардагдах хөрөнгийг хавсралтаар баталж, 1,496,000 (Нэг сая дөрвөн зуун ерэн зургаан мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны ...сарын ...-ны өдрийн
... дугаар захирамжийн хавсралт



СУРГАЛТАД ХАМРУУЛАХАД ШААРДАГДАХ
ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг Бүрийн үнэ	Нийт үнэ
1	Сургалтад оролцогчдын зардал	ш	4	374,000	1,496,000
Нийт зардал					1,496,000